**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр　　Дугаар А/101　　Улаанбаатар хот

Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч,
захирал нарын 2024 оны ажлын гүйцэтгэл,
үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх
үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоол, 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, захирал нарын 2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Ахлагч: | Б.Болормаа Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч |
| Гишүүд: | Л.Санжийжамц Засаг даргын Тамгын газрын дарга |
| | Б.Отгонжаргал Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга |
| | Ц.Мягмарсүрэн Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга |
| | Б.Цогжавхлан Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга |
| | Д.Хүрэлбаатар Тохижилт, худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтсийн дарга |
| | Ш.Бат-Өлзий Цэргийн штабын дарга |
| Нарийн бичиг: | Д.Оюунбаатар Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Захиргааны зохион байгуулалт, гүйцэтгэлийн төлөвлөгөө, хороо хариуцсан мэргэжилтэн |

2.Холбогдох хууль тогтоомжийг судлан, үнэлэх ажлыг хагас жилээр 2024 оны 06 дугаар сарын 17-ны дотор, бүтэн жилээр 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор зохион байгуулж, 7 хоногийн дотор үр дүнгийн үнэлгээг танилцуулахыг Үнэлгээний багт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА　　А.СҮХБОЛД

AJIL\2024 он ажил\захирамж

1123200271